

## “NOMADIC REALISM” БУЮУ “НҮҮДЭЛЧНИЙ РЕАЛИЗМ”

До.Цэнджав

**Түлхүүр үг:** *nomadic realism*, нүүдэлчний реализм, бэлчээрийн мал аж ахуйн соёл сэтгэлгээ, уламжлалт соёл ухаан,

Юмс, үзэгдлийн бодит ахуйлаг тусгал, сэтгэлгээг гол үндэслэл, гол үндсэн арга болгосон философийн үзэл санааг урлаг, уран зохиолын үндсэн арга гэж үзсэн түүх нэн эрт үеийнх юм. “Реализм” гэх томъёоллыг бүтээлдээ хэрэглээгүй боловч 2400-аад жилийн өмнө эртний Грекийн агуу гүн ухаантан Аристотель урлаг, уран зохиолыг дур зоргын хийсвэр санаагаар биш, бодит үнэнийг дууриалган харуулах зарчим бүхий зохиол судлалын онолын нэг ойлголт болжээ. Материаллаг юмс анхдагч гэх философийн урсгал чиглэлийг туулж, хүчирхэг онол болтолоо уналт, сэхэл, гажуудал сэргэлтийг үзэж, олон урсгал чиглэл салаалан гарч, нийлж салсаар ирсэн зүй тогтолтой. Уран зохиолын реалист арга нь хүмүүн болоод нийгмийн амьдралын догматик хуулбар биш, хөгжил хөдөлгөөнтэй, зөрчил тэмцэлтэй, итгэл үнэмшилтэй, амьдралын үнэнийг нээсэн, цагийн хувьсалт өөрчлөлтийг тэсвэрлэж давж гарах чадвартай шалгагдсан хүчирхэг арга мөн. Объектив бодит үйл явдлыг уран зохиолд дүрслэн харуулах нь торхтой цөцгийг ямар ч халбагаар хутгаж болдгийн адил уран зохиолд шаардлагагүй, хэрэгцээгүй урсгал чиглэл байхгүйн адил реализмын олон талт урсгал чиглэлийг мөн л олон талаас нь нээж урлах үндсэн арга барил болгох шинэ шинэ замыг эрэлхийлэх нь чухал юм. Харин “Социалист реализм” гэх томъёолол И.В.Сталины санаа дэвшүүлснээр Зөвлөлтийн уран зохиолд гучаад оноос гарч ирснээр реализмын сонгодог санаа, мөн чанарыг гуйвуулж, марксист ленинист онолын улс төрийн агуулгаар тайлагдан, уран зохиолыг нэг намын үзэл санаанд үйлчлэх зэвсэг, арга хэрэгсэл болгосноор уран бүтээлч чөлөөт сэтгэлгээг хаан боогдуулж, агуулга, хэлбэр, арга барилыг явцууруулан ядууруулж, түүхэн үнэнийг гуйвуулж, дур зоргоор хандахад хүргэжээ. Гэвч өнөөдрийн өрнөдийн олон урсгалт дан ганц хийсвэр сэтгэлгээт уран зохиолын онолын үүднээс харж, өнгөрсөн зуунд зохиолчдын бүтээсэн оюуны асар их өвийг бүхэлд нь “социалист реализм” гэдэг үгүйсгэлийн үгүйсгэлийн “чөтгөрийн тойрогт” хавтгайруулан оруулж үгүйсгэх, бүдгэрүүлэх, гутаах, мушгин гуйвуулах хэрэгсэл болгох нь хоосон хийрхэл, төөрөгдөл, туйлшрал болно. “Социалист реализм бол уран зохиол, урлагт нийгмийн захиалгаар цаг хугацаа - орон зайд марксист улс төрийн үзэл суртал, нөхцөл шалтгаан, шаардлагаар бий болсон гажуудсан урсгал чиглэл мөн” гэж үзэж болно.

Социалист реализмыг сонгодог реализмтай нийлэгжүүлэн хольж хутгах нь утгагүй хэрэг. “Урлаг, уран зохиол байгаа цагт реализм байх болно” гэж утга зохиолын онолч Ц.Хасбаатар эрс шулуулан хэлжээ. “Уран зохиолд тайлалзүй (*hermenevtic*) нэвтэрснээр барууны уран зохиол судлалд онолын хатуу хүрээнээс гарч, сэтгүүлзүй-эссеней чиглэл хандлагыг олжээ (С.Энхбаяр). Энэ утгаар бидний өөрийн орны уран зохиолын олон талт үзэгдэлд хийсэн ажиглалт, туршилт, тайлалзүйгээрээ социалист реализмын зарчмаас өөр Монголын үе үеийн

сэхээтэнлиг зохиолчдын оюуны үнэт зүйлс, өв болох “Nomadic realism” буюу “Нүүдэлчний реализм” гэж болохоор урсгал чиглэлийг багтаан агуулсаар иржээ гэсэн шинэлиг асуудлыг дэвшүүлэн гаргаж байна.

Төдий л ярьж хэвшээгүй, ингэж үзэж, бичиж байгаагүй болохоор “Нүүдэлчний реализмыг” юу гэж ойлгох вэ? гэвэл асуудал аяндаа гарна. Энэ бол ямар нэгэн “измийн” нээлт шахалт шаардлага бус, зохиомол сэдэл санаа ч биш Монголын уран зохиолын амьдрал, хөгжлийн түүх, зохиол туурвилын гүн бүтэц бэлхнээ харуулж байгаа ажиглалт, сэдэл, баталгаа, нотолгоо юм. Ардын аман зохиол, домог, туульсад бодит байдлаас хийсвэрлэл рүү чиглэсэн сэтгэлгээ, хандлага чиглэл илүү илэрдэг. Тэгвэл *“Нүүдэлчний реализм нь олон зуун жилийн турш оюуны өв, үнэт зүйлс болтлоо хэвшиж уламжилж ирсэн мал аж ахуй, түүний бэлчээр орчин, идээшлэгийг дагасан соёл, монгол үндэсний маш өвөрмөц сэтгэлгээт байгалийн орчин, эх монгол хэлний өвөрмөц содон илэрхийлэл, өвөг нүүдэлчдийн амьдралын хэвшил, ахчилах эгчлэх тахимдуу ёс, сургаал ачлал, мөс жудаг, зан заншлыг уран сайхны аргаар нээж хүмүүн төрөлхтний уран зохиолын өвд оруулсан үнэт зүйлс мөн”* гэж томъёолж болно.

Монголахуйг өөр ямар ч орны ахуйтай зүйрлэж харьцуулахын аргагүй. Нүүдэлчний амьдрал, суурин амьдрал хоёр эрс тэс ялгаатай хоёр өөр соёл, өөр зан заншил, өөр сэтгэлгээ, ертөнцийг үзэх өөр философи, содон өвөрмөц хэв маяг мөн. Нүүдэлчдийн атар онгон байгальдаа нэвчсэн амьдрал ахуй нь асар хүнд бэрхшээлийг туулж сөрж ирсэн ухаанаас үүсвэртэй эш онолжиж, оюунжиж, гэгээрч, аргажин туршлагажиж, хар бор ухаанаас харьцуулшгүй сод ухаан төрүүлж, давтагдашгүй өвөрмөц амьдралыг бүтээж ирсэн тийм хосгүй амьдрал чухамдаа нүүдэлчин Монгол орны оюуны үнэ цэн юм байна. Ерөөс нүүдэлчний амьдрал бол байгаль, цаг уурын хатуу сорилт доторх гүн ухаан мөн. Байгаль ертөнцийн содон үзэгдэл гүн ухааныг бий болгодог. Нүүдэлчин монгол ухаан бол хүн төрөлхтний ухаанаас ялгарах ухамсар, сэрэл, мэдрэмжийн дээд хэлбэр төдийгүй үүнээс үүссэн ертөнцийг өөрөөр үзэх философи юм. Монгол ардын зүйр цэцэн үг, ертөнцийн гурав, оньсого таавар, уртын дуу, ерөөл магтаал, туульс, дом шившлэг зэрэг нь нүүдэлчний монгол ухаан, үг ухааныг ширээсэн урлагийн дээд зөн мэдрэмж, дархлаат өвөрмөц сэрэл, сэтгэхүй юм.

Өнөөгийн Америк гүрэнд “Amish people” гэгчүүд 1600-1700-аад оныхоороо, яг тэр ахуй, амьдралын хэв маягаар, орчин үеийн ахуй амьдралаас бүрмөсөн таслагдсан бараг 200 мян. гаруй хүн байдаг. Суурин амьдралыг эрс эсэргүүцдэг, техник технологийн хөгжил дэлхийн ирээдүйг сүйрүүлнэ, хүн орчны байгаа үндсэн төрх байдлыг өөрчлөх нь байж болшгүй нүгэл, хүчирхийлэл, гаж үзэгдэл гэж үздэг, улсдаа татвар төлөхгүй, цэргийн алба хаахгүй, гэр цахилгаан, радио телевиз гээд орчин үеийн бүх техникийг хэрэглэхгүй, өөр угсаа гарлын хүмүүстэй гэрлэхгүй, зөвхөн морь, морин тэрэг унаж, тэр дундад зууныхаа үеийнхээрээ хувцасладаг, зөвхөн гар хөдөлмөр эрхэлдэг сонин хачирхалтай хүмүүс байх юм. Эднийг манайхтай адил төстэй нүүдэлчин амьдрал ахуйтай харьцуулан үзэхийн аргагүй, зүгээр л XVII зууныхаараа амьдардаг цус ойртож, сэтгэлгээний нэгэн хэт туйлширсан хэв загварт орчихсон, Христийн шашны өрөөсгөл үзэлт, хоцрогдсон ахуй, ертөнцөөс таслагдсан хүмүүс юм. Монголын нүүдэлчин ахуй амьдралыг “амишууд”-тай зүйрлэхийн аргагүй, асар чөлөөт сэтгэлгээтэй, далдын зөнч, совинлог ухаантай, од гарагийн нууцад нэвтэрсэн тэр чинээгээрээ байгаль, хүмүүсийн эрхшээлд дарлагдаж биш, сөрж амьдрагчид, оюуныг болоод нүүдлийн мал аж ахуйн материал баялагийг бүтээгчид юм. Монголчууд 5000 уртын дуу зохиож, 600 од гаригийг монгол нэршлээрээ нэрлэж, 64 оронтой тоог монгол үгээр томъёолон тоолж, холбоо үгтэйгээр нь тооцвол хэдэн ч саяд хүрэхээр үг хэлээр уран бүтээл, соёл түүхээ бүтээдэг, туурвидаг ард түмэн юм. Ямархан оюуны арвин ай савтай ард түмэн байсныг академич Д.Цэрэнсодном “Монгол уран зохиол” (XIII-XX зууны эхэн) бүтээлдээ *“Хан харанхуй” тууль*

нь сарын газар аян жин тээн явахдаа очих замдаа хайлж, эхлээд буцах замдаа дуусгадаг байсан ажээ" (1987:61) гэж тэмдэглэсэн байна. Захын жишээг дурдвас энэ мэт далай мэт авьяас оюуны агуу ай савтай билгийн нүд нээгдсэн ер бусын билэг авьяастнууд гэдэг нь маргашгүй.

"Монгол ухаан" гэж тусдаа зүйл байхгүй, ертөнцийн ухаан л гэж бий хэмээн зарим нь үгүйсгэдэг ч гэлээ нүүдэлчдийн амьдрал, ахуй, байгаль огторгуйтай харьцах жилийн дөрвөн улирлыг тайлагч ухаан монгол ухааныг бий болгосон төдийгүй, тэгж ярьж бичиж болно гэдэгт итгэдэг. Үгээр, аялгуугаар, чухамдаа морин хуурын эгшгээр хүнийг биш, малыг уяруулан хайлуулж, ботгоо голсон ингэний нулимсыг асгаруулан аванхайлан дуулж, эх үрсийг эвсэлдүүлэн нийлүүлдэг жишээ говь нутагт захаасаа аван бий. Нүүдэлчин ардын энэ арга ухааныг нээн харуулсан "Ингэн нулимс" кино аль хэдийн олон улсын кино наадмаас тэргүүн шагнал хүртэж байсан, хожмынхон ч энэ чиглэлийн бүтээл туурвиж, олон улсын хэмжээний кино наадамд томхон амжилт олсон нь бий.

Нүүдэлчин монгол ухаанаас ганцхан жишээ хэлэхэд, намрын дунд сарын шинийн арван таванд нутгийнхаа уул, чухамдаа Ерлөг хайрхан дээр гараад, задгай түүдэг галаа тойрон сууцгааж, шөнийн турш хар нүд анилгүй дөрвөн зүг, найман зовхис руу дурандаж, өртөө газрын тоос хярхгийг ч андахгүй шинждэг, заримдаа хулганын тоосыг хүртэл ажиглаж мэддэг, мэдэрдэг "ардын байгаль шинжээчид" буй. Тэд ирэх өвлийн байгаль цаг уурын дүн нурууг хэлэлцэж, нутгийн малчин ардуудад тэр уулаар оторловол малын тамга цохих хөлгүй их цас бууна, энэ хөндийд малын хар туруу цастай байна, энэ хавиар нутаглавал өвөлд өнтэй орж, хүн мал хавартайгаа энх мэнд золгоно гэж шинждэгхэсэг хүмүүс Дундговь аймгийн боржигон талын нутаг усанд бий. Энэхүү ардын цаг уур шинжээчдийн сорил, таамгийг цаг уур судлалын эрдэмтэн, мэргэжилтнүүд олон жилийн турш судлаад, шинжлэх ухааны туршилтаас зөрөөгүйг баталсан нь сонирхолтой. Энэ бол монгол ухаан газрын татах хүчнээс тасарч, дээд огторгуй, одон гаригтай шууд харилцаж, холбогдож байна гэсэн үг. Нүүдэлчин ахуй амьдрал, ёс заншил, уламжлал, өвөрмөц содон амьдрал, сэтгэл сэтгэлгээ, хэлц хэллэг, соёлыг бүтээл номдоо тусгавал хожим хойтын уран бүтээл туурвигчдад тус нэмэртэй болов уу? гэж санаж явдгийн хувиар үүнийг бичиглэгч "Оддын судар" өгүүллэг бичсэн нь бидний үзэж байгаагаар "Нүүдэлчний реализмд" хамаарах болов уу?

Профессор С.Дулам *Өдрийн сонин*-ы нэгэн дугаарт өгсөн ярилцлагадаа "Францчууд рационализмаас нэлээд хөндийрч, уйдсаншинжтэй байна" гэсэн утга бүхий үгийг хэлсэн нь жирийн хэрэг биш. Хэт оюунжсан, танин мэдэхүйн ээдрээтэй хийсвэр чиглэлээс амьдралын үнэнийг эрж хайх, хүсэх тэр үе цаг руу орж байгааг илтгэнэ. Ерөөс өнгөрсөн XX зуунд ч, энэ шинэвтэр зуунд ч уран зохиол, ялангуяа роман мэтийн хүүрнэл зохиол эсээжих, баримтжих, бодитжих чиг хандлага хүчээ авсаар, "баримтат уран зохиолын эрин зуун" гэж зүй ёсоор нэрлэгдсээр ирлээ. Гэхдээ энд нэг зарчмыг хатуу баримтлах ёстой. Баримтат гэдэг бол хув хуурай хоосон тэр зүйл биш, урлахуй, уран сайханжихуй, найруулахуй, зохиомжлохуй, урнаар сэтгэхүйтэй салшгүй холбоотой амьд, сонирхолтой хэлбэрийн бүтээл мөн. Дашрамд тэмдэглэхэд, амьдралын бодит үнэн ба хийсвэрлэл сэтгэхүйн задралыг хооронд нь зохистойгоор холбон уялдуулж, уран сайхны нээлт хийж чадвал шинэ зууны шинэчлэлийн үр хөврөл энд байгаа гэхэд болно.

Монголын их уран зохиолын доторхи нүүдэлчний сэтгэлгээт урсгал чиглэл нь дэлхийн хэмжээний уран зохиолын чиг хандлагыг өөрчилж, шинэчлэх сэрэл мэдрэмжийг өгөх хувьслыг хүлээн зөвшөөрөгдөх эсэх нь зохиолчдын нээлт тэсрэлт бүхий авьяас билэг, гүн сэтгэлгээ, ур чадвараас шууд шалтгаална. Үүнтэй зэрэгцээд, англи хэлийг гүнзгий эзэмшсэн

дэлхийн хэмжээний сод онцгойрсон уран сайхны шинжлэл, судлалын хүчирхэг төлөөлөгчид гарч ирэхээс хамаарна.

Манайхныг хөл алдан тоодоггүй шахуу байсан хуучин Зөвлөлт засгийн үеийн судлаачид Бэгзийн Явуухуланг “Дорнын их яруу найрагч” гэж үнэлсэн нь одоо ч бидний бахархал болсоор байгаа, байх ч болно. Энэ эрхэм найрагчийн бүтээлд социалист реализмын өчүүхэн ч үнэр шингээгүй, зөвхөн утга уянгын найрагтаа үнэнч байсан төдийгүй, нүүдэлчний сэтгэлгээг гүнзгий шингээснээрээ ийнхүү их гүрний дээдсийн шалгуурт хүлээн зөвшөөрөгдөн үнэлэгдэх хэмжээнд хүрчээ.

“Нүүдэлчний намар”

*Нарс найгаад л*

*Навчис хийгээд л*

*Уулын оройд цан суугаад л*

*Шувуу буцаа л*

*Хяруу унаа л*

*Өвсөн толгойд цан буугаа л*

*Тал шарлаад л*

*Мал холхио л*

*Малчны сэтгэл гэнэт доглоод л*

*Салхи сэвээ л*

*Өрх дэвээ л*

*Өлөн тоос тэнгэрт босоо л*

*Айлууд нүүгээ л*

*Амрагууд холдоо л*

*Аяа хөөрхий нүүдэлчний намар аа гэж...*

Б.Явуухулангийн дээрх шүлгийн мөрийг авч үзвээс үг бүрийг хүчлэн шүлэглэн буулгасан биш, “найраг төрөхийн зөнгөөр” өөрөө аяндаа сул зөнгөөрөө буусан мэт энгийнээс энгийн агаад яруугаас яруугийн үл ажиглагдам эрчис хүчний гүнзгийрсэн амьсгалыг мэдрүүлсэн жишээ энэ. Харь орны ямар ч том найрагчид ертөнц хорвоогийн түм түмэн өнгөт намар, намрын дотроос манай нүүдэлчний ийм намрыг ингэглээ ажиглаж мэдэрч, тархиндаа буусныг ингэж дүрслэн буулгаж, хүмүүний сэтгэл гэгэлзэж, доголзтол яахин амжихав дээ.

Зохиолч Чинагийн Галсан герман хэлээр зохиолоо туурвиж, түүнд алдарт Шамилсоны зэрэг олон улсын нэр хүндтэй шагнал олгохдоо “Германы уран зохиолыг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулж, герман хэлийг хөгжүүлж, германы уран зохиолын цусыг нүүдэлчдийн сэтгэхүйгээр сэлбэлээ” гэж үнэлсэн нь чухамдаа нүүдэлчдийн хэл сэтгэлгээ, амьдрал ахуйн бодит сэтгэлгээг үнэлсэн хэрэг юм. Нүүдэлчин Монголын ахуйн уламжлалт урлаг ч гадаадын чих дөжирсөн нүргээнт хатуу рок чиглэлийн урлагийн “цусыг сэлбэж” нэр хүндтэй наадмуудад шалгарч байгаа нь мөн нүүдэлчдийн олон зуунаар өвлүүлэн хүрч ирсэн үндэсний хөгжмийн аялгуу болоод түүний содон найруулгыг лимбэ, хэнгэрэг цан, алтайн хүннү ятга, шанз, хөөмий зэрэг зэмсгүүдээс харж болно. Холливудын киноны найруулагчид ч нүүдэлчин ахуй амьдралыг шохоорхож, манай үндэсний дуу хөгжим, жүжигчдийн ур чадврыг ашигладаг болж байгаа нь дээрх жишээг батална.

Өнөөдөр ардчилсан үзэл санаа гэж онцгойлон ярих боловч тэрхүү ардчиллын үзэл санаа ерөөсөө монголчуудын мах цусанд аль хэдийнээс шингэсэн ард түмэн юм. Тал хязгаар нутагтаа эрх дураараа нүүдэллэж, эрх дураараа үг хэлэлцэж, эрх дураараа амьдарч, тэмцэж ирсэн ард

түмэн. Тиймдээ хаа ч очсон дасан зохицох онцгой чадвартай. Европ, Америкийнхан орчин үеийн тансаг амьдралаас хөндийрч, улам бүр "дорноджиж" эгэл энгийн натур амьдрал руу тэмүүлэн, хуучин эд өлгийн зүйлс, онгон зэрлэг байгалийг илт шохоорхох болсон нь мөнөөх нүүдэлчний амьдрал руу тэмүүлж байгааг харуулна.

90-ээд оноос хойш өнгөрсөн "социалист реализмын" хэмээх 70 жилийн уран зохиолыг дан ганцхан социалист реализмыг шүтэж ирсэн, нэг намын үзэл суртлыг номлосон, хэт улстөржин гажуудаж, дэглэгдсэн уран зохиол гэж шүүмжилсээр ирснийг эрхбиш дотор гадрыг шүүн тунгаавал өөр талаас нь харах, цэгнэх цаг болжээ.

Модернизм дотроо олон урсгалтай шиг реализм басдутахааргүй олон урсгал чиглэлтэй. "Дорнын реализм" гэсэн томъёолол дэлхийн уран зохиолын шинжилгээ судалгаанд үзэгддэг боловч, бидний авч үзэж байгаа "Нүүдэлчний реализмаас" ангид өөр, бие даасан урсгал чиглэл гэж болно. "Дорнын реализм" гэдэгт хавтгайруулан оруулж үзвээс, Азийн олон олон орны янз бүрийн түүх уламжлал, ёс заншилтай тэр тусмаа бэлчээрийн мал аж ахуйтай төсөө зүйл огтхон байхгүй, таньж мэдэх ч үгүй, зөвхөн газар тариалангийн соёлтой суурин тосгоны амьдрал ахуйтай яахин зохицолдох аж. Иймээс дээрх санаагаа баталж, бие даасан урсгал чиглэл гэдгийг дахин давтан хэлье.

Ямар нэгэн үзэл суртлын захиалгатай гэхээргүй бас дотроо олон урсгал чиглэлийг агуулж байсан "Нүүдэлчний реализм" гэж болохоор монгол ахуй амьдралтай нягт барьцалдан нөхцөлдсөн арга хэлбэрээр бичсэнийг ажиглаж шинэ үеийн Монголын уран зохиолын түүх, судлалын бүтээл, сурах бичгүүдэд тусгайд нь авч үзээсэй гэсэн санааг үндэслэж байна. Зохиолчдоос Д.Равжаа, Д.Нацагдорж, С.Дашдооров, С.Эрдэнэ, Б.Догмид, П.Пүрэвсүрэн, С.Пүрэв, Д.Норов, Ж.Лхагва яруу найрагчдаас Б.Явуухулан, Д.Пүрэвдорж, Ш.Сүрэнжав, Т.Галсан, Д.Нямаа, Д.Цоодол, П.Бадарч, Г.Мэнд-Ооёо нарын зэрэг энд бүтэн нэрлэгдээгүй бусад олон зохиолч, яруу найрагчдын бүтээлийг энэхүү "Нүүдэлчдийн реализмд" хамаатуулж болохыг тоочивч баршгүй. Ганц жишээ дурдахад, *"Монголын зохиолчид дундаас хамгийн монгол нь Дашдооров. Говийн монгол амьдрал, говийн хүний хар бор дүрийг Дашдооровоос илүү уран нарийн бөгөөд ил тод гаргасан өөр зохиолч байхгүй"* хэмээн их зохиолч С.Эрдэнээс ончтой үнэлгээ авсан Ардын уран зохиолч С.Дашдооровын "Бууж үдлэх хорвоо" нүүдэлчдийн реализмын" сонгодог жишээ гэхэд болно. Энэ өгүүллэгийн өгүүлбэр бүрийгнухацтай шүүн тунгааваас дүрийн үг хэллэг, дотоод бодрол, монгол өвгөний сэтгэлзүй, зан суртахууны хандлага, байгаль орчны ахуй, нүүдэлчдийн ёс намбархаг төрх, уламжлалт дүрслэлийн сан хөмрөг гэж болно. Төгөө өвгөн хониныхоо бэлчээрт Ангаа хэмээн нутаг усандаа хүндлэгдсэн Хангай өвгөнийг нас нөхчжээ гэдгийг Самбаагаас дуулаад, баярлуулж ер үзээгүй юмсанж гэж дотроо харамсана. Төгөө оршуулганд оролцъё гэвч бололцоо гарсангүй. Гэхдээ нэг ухаан сийлж байна. Ная хүртэл насалсан Хангай өвгөнийг хөдөөлүүлэх газар болох Хан-Өндөр уул руу хонь, адуугаа гилж бэлчээдэг. Энэ нь цаанаа их учиртай ажээ. Учир нь өгүүллэгийн төгсгөлд тайлагддаг: *"Өвгөний сүүлчийн замд халуун хошуутай мал дараа дараагаар дайралдлаа гэж зөндөөн баярлаж бэлгэцшээжбайна лээ. Хэр шүү дээ, тийм явдал ховор байдаг юм"* гэж хэлнэ. Төгөө "Намайг тийшээ зориуд гилсэн" гэдгийг эд яаж мэдэхэв гэж бодож байгаагаар өгүүллэг төгсөнө. Энд өөр хаа ч байхгүй ёс жудаг заншил болох нүүдэлчний монгол ухаан тэр чигээрээ шингэжээ. Магадгүй харийн хүн бол "Би зориуд хөдөөлүүлэх замын дагуу халуун хошуут малаа бэлчээрлүүлж аваачсан" гэж гайхуулж болох юм.

Дэлхийн гарамгай яруу найрагч цол хүртсэн Д.Нямаагийн зууны манлай шүлэг болох "Шөнийн талд адуу янцгаана" шүлэгт:

Эртний домог шиг буурал тал  
 Эргэн тойрон чимээ алдарна  
 Алс замын алжаал тайлж  
 Аяны хүн талдаа хононо  
 Гүн харанхуйд тэнгэрийн зүйдэл  
 Гүүн зэл шиг сунайн цайрна  
 Амгалан талын аяс хөндөж  
 Алдуурсан унага шиг од харвана  
 Эртний домог шиг буурал тал  
 Эргэн тойрон чимээ алдарна  
 Оддын дунд ижлээ үзсэн юм шиг  
 Шөнийн талд адуу янцаана

гэжээ. “Тэнгэрийн зүйдлийг хаа байсан доод газрын гүүн зэлтэй ижилсгэн зүйрлэж, талын аяс хөндөгдөхөд л алдуурсан унага шиг од харвадаг “Тэнгэр газрын холбоо хамаарлын” яруу тансаг, гоозүйн гүн ухааныг нобелистууд ч нэг л амжихгүй болов уу? Үүнийг нүүдэлчин монгол яруу найрагчийн ухаан гэхгүй бол өөр ямар ухааныг үүнтэй зүйрлэх вэ? Ази тивд Япон, Өмнөд Солонгос, Хятад, Монгол энэ дөрөвхөн орон л үндэс уламжлал, өвөрмөц төрх, сэтгэлгээ, хөгжил хөдөлгөөнөөрөө энэ агуу том тивийн яруу найргийн туйлчилсан хөгжлийг манлайлж байна хэмээн үнэлж, тэднээс Д.Урианхайг онцлон “Азийн тэргүүн найрагч” шагнал олгосон нь манай яруу найргийн хөгжил нүүдэлчдийн соёл сэтгэлгээнд тулгуурлавал хаа ч хүрч болохыг харуулна.

Энэ мэт чиглэлийн зохиолыг “социалист реализм” гэсэн ганцхан аргад оруулан таягдан хаялгүй, тэрхүү нэгэн хэвийн загварчлалаас ангижруулан салгаж, “Нүүдэлчний реализм”-д хамаатуулах нь шалгарлын онолоор ч, утга зохиол судлалын зарчимд ч тохирно гэсэн асуудлыг энэ өгүүллээрээ дэвшүүлж байна. Дэлхийн уран зохиолын нөлөө бүхий нэвтэрхий толиудад ийм томъёоллыг оруулахыг чармайх нь Монгол орны нэр хүндэд ч ихээхэн чухал зүйл юм.

Монголын уран зохиолыг даянд гаргах боломж, нөхцөл, шаардлага нь энэхүү “нүүдэлчдийн реализмд” тулгуурласан шилдэг бүтээлүүд байж болох юм. Нүүдэлчдээс төвдүүдийн амьдрал ахуй, бясалгалт сэтгэхүйтэй шашинлаг гүн хаанаас нээлт гаргаж, Нобелийн шагналд хүрсэн эрдэмтэд төрж байгаа нөхцөлд Монголын нүүдэлчдийн өвөрмөц онцлог, сэтгэлгээдутах зүйлгүй нь мэдээж юм. Байгаа зүйлийг байгаагаар нь харж хэлбэл ийм л байна. Бодит зүйлийн тусгал туйлдаа хүрэхгүй, олон шинж чанартай байдаг болохоор домог зүйн реализм, соён гэгээрүүлэх реализм, сэргэн мандалтын реализм, дахин сэргэлтийн реализм, шүүмжлэлт реализм, сюрреализм, романтик реализм, америк, европын реализм, сэтгэлзүйн реализм, болзолт бас болзолт бус реализм, хувьсгалт реализм, социалист реализм, бүдүүлэг реализм, ширүүн реализм, зөн совингийн реализм, ардчилсан реализм (Ц.Хасбаатар) нарийвчилбал, Грек-Ромын реализм, Байрон, Пушкиний реализм хэмээн олон янзаар томъёолдог болохоор тэр олон реализмын дотор Монголын үндэсний сэтгэлгээний мөн чанар, унаган төрх, хэл сэтгэлгээг шингээн харуулсан “Nomadic realism” буюу “Нүүдэлчний реализм” байр сууриа олох нь дамжиггүй. Манай утга зохиол судлаачид, шинжээчид ийм нэгэн томъёоллоор ярьж, бичиж хэвшвэл дэлхийн уран зохиол судлалын нэгэн хэсэг, бүрэлдэхүүн болох магадлалтай санагдана.

Дүгнэлт

Олон зуун жилээр бэлчээрийн мал аж ахуйг шүтэж ирсэн монголчуудын өнө эртний нүүдэлчдийн ёс заншил, уламжлал, хэл сэтгэлгээ, өв соёлыг харуулсан бүтээл туурвил маш олноор төрж, өвөрмөц онцлогтой, биеэ даасан нэгэн урсгал болжээ. "Nomadic realism" буюу "Нүүдэлчний реализм" гэх шинэ нэр томъёог судлаач шинээр дэвшүүлж, уран зохиолын онолын сэтгэлгээг өргөтгөн хөгжүүлэхэд судлаачдын анхаарлыг чиглүүлжээ. Үүнийг 90-ээд оноос хойш хурц шүүмжлэлд өртсөн "социалист реализмын" аргаар бүтсэн зохиолуудаас тусгайд нь саланги авч үзэх шаардлагатай гэж дүгнэсэн байна. Нэг намаар удирдуулсан 70 жилийн уран зохиолыг дан ганц "социалист реализмын" аргаар бүтээсэн гэсэн үгүйсгэл, туйлшрал чамгүй газар авсныг өөр өнцгөөс харж, "нөхцөл боломж - цаг хугацаа - орон зайн" үүднээс шалгарлын онолоор хандахад анхаарлаа хандуулжээ. Нэг намын үзэл сурталд огтоос хамааралгүй Монгол нүүдэлчин ахуйг тусгасан олон арван зохиол бүтээл, энэ чиглэлээр дагнан туурвидаг олон зохиолчийн бүтээлийг "Нүүдэлчний реализм" гэсэн томъёолд оруулах санаа гаргасан байна. Хэрвээ нэгдсэн ойлголтод хүрч, ийм томъёоллоор дүгнэж уран зохиолын түүх, сурах бичиг, нэвтэрхий тольд тусган оруулбал дан ганц социалист реализмыг шүтсэн уран зохиол байгаагүй монгол үндэсний сэтгэлгээ, философи бүхий хөгжиж ирсэн, хөгжиж ч багаа Монголын уран зохиолыг дэлхийд гаргах боломжтой онол, практикийн ач холбогдолтой төдийгүй, манай орны нэр хүндэд ч тустайг өгүүлэл бичигч онцолсон байна.